



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

**ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ГАНБАТ ТАНАА**

2025. 05. 19 № 9/1099

танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 07-оос 2025 оны 05 дугаар сарын 09-ний хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 26-ний өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан Засаг даргын 2025 оны А/30 дугаар захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталсан байна.

Тус хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн бодлого огт тусгагдаагүй бөгөөд сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөгөөнд мөн тус чиглэлээр зорилт, арга хэмжээ тусгагдаагүй орхигдсон байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хөгжлийн хөтөч хөтөлбөр тусгагдаагүй.

Сумын төсөвт байгууллагууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд суурилж боловсруулаагүй байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан боловч төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдаагүй байна. Иймд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орхигдсон бодлогын чиглэлд холбогдох зорилт, арга хэмжээг нэмж шаардлагатай засваруудыг хийж дахин батлуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах талаар холбогдох мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа

Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог жил бүр шинэчлэн баталдаг. Салбар зөвлөлд төсвийн шууд захирагч болон төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтан хүргүүлж хэвшсэн.

231060306

2.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Н.Түвшинжаргал нь сумын Засаг даргын 2016.07.01-ний Б/08 дугаар захирамжаар сонгон шалгаруулалтгүй томилогдсон. Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Өнөржаргал Боловсролын газрын даргын 2023.10.20-ны өдрийн Б/57 дугаар тушаалаар томилогдсон, сонгон шалгаруулалтад орсон гэх боловч нотлох баримт бичиг байхгүй, хувийн ашиг сонирхлын урьдчилсан дүгнэлт гаргуулсан эсэх нь тодорхойгүй. Соёлын төвийн дарга Ж.Ариунгэрэл нь сумын Засаг даргын 2023.10.27-ны өдрийн Б/32 дугаар захирамжаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр хувийн ашиг сонирхлын урьдчилсан дүгнэлт гаргуулаагүй томилогдсон.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Сургалтын менежер Д.Чинбатыг Боловсролын газрын даргын 2024.09.12-ны өдрийн Б/83 дугаар тушаалаар томилсон байна. Гэтэл захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Чинбат нь багш Д.Бямбадоржийг Сургалтын менежерээр 2024.11.07-нд (Б/43) томилж, 2024.11.22-нд (Б/44) 4 дүгээр ангийн багшийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгох тушаалыг тус тус гаргасан байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолт 2025 онд шинэчлэн батлах зөвшөөрөл олгосон Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан хэдий ч Тамгын газрын даргын тушаалаар шинэчлэн баталж гаргаагүй байна. Нийгмийн бодлогын мэргэжилтний албан тушаалд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнийг шилжүүлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025.01.06-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар томилсон нь тус албан тушаалын тодорхойлолтын тавигдах тусгай шаардлагын мэргэжлийн индекс таарахгүй байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд зарим албан хаагчийн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэнийг нотлох баримт бичиг, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нэр дэвшүүлсэн тогтоол байхгүй, хөдөлмөр эрхлэлтийн тушаал шийдвэр дутуу, албан тушаалын картыг бүрэн гүйцэд хөтлөөгүй зэрэг дутагдал байгаа тул хүний нөөцийн шийдвэр гаргах, хувийн хэргийн бүрдүүлэлт, албан тушаалын картыг зөв хөтлөх зэрэг анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орхигдсон бодлогын зорилт арга хэмжээг нэмж, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт тус бүрийг арга хэмжээ болгон задлах

2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээг бүрэн тусгах

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар

хавсралтаар буюу батлагдсан загварын дагуу тус тус төлөвлөх (сумын Соёлын төв анхаарах)

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

5. Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, тайланг хэн хариуцах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

7. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг төрийн жинхэнэ албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задалж боловсруулах (албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах)

8. Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчилсан байдлаар оновчтой тодорхойлох

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1. Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлах шаардлагагүй бөгөөд Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчлөх

2. Албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах

3. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйл, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

4. Төсвийн шууд захирагч нарын томилгоог хийхдээ хууль тогтоомжид нийцүүлсэн эсэхийг сайтар шалгах

5. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер томилсон шийдвэрийг хуульд нийцүүлэн залруулах

6. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АЖАРГАЛСАЙХАН

